

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-8
2.	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	8-66
	<b>1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</b>	12-22
	<b>2. “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай”, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай”, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд</b>	22-45
	<b>3. “Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>	45-66

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 17 гишүүн ирж, 94.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: У.Хүрэлсүх.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцүүлгээс 3 өдрийн завсарлага авч байгааг мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

**Нэг.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Судлаач, хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар, “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн зөвлөх Г.Сувд нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх О.Цолмон нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Амарсайхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Г.Ганболд, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор аймаг, сум, нийслэл, дүүрэг эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 18 дугаар зүйлийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч” гэсэн гарчгийг “Аймаг, сум, нийслэл, дүүргийн өмч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 7  
Бүгд: 12  
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан

горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энх-Амгалан:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Л.Энх-Амгалан:** 3.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зарчмын зөрүүтэй 3 дахь санал дэмжигдвэл Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “нийслэл,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 61 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 61.1.22 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“61.1.22.сумын Засаг даргын орлогч, Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 62 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 62.1.22 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“62.1.22.аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан,

Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь Үндсэн хуулийн 6.2-т зааснаас бусад өмчтэй байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 8  
Бүгд: 13  
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан,

14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.3 дахь хэсэг нэмэх:

“14.3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэрийг төрийн албан ёсны хэлээр нэрлэж, хаягийг монгол хэлээр нэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт саналаа тайлбарлав.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн 11 цаг 02 минутаас хуралдааныг даргалав.*

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан,

Төслийн 14 дүгээр зүйлийн гарчгийн “зааг” гэснийг “нэгжийн нэр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт гаргасан саналаа татаж авав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

## **ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

***Нэг.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Нэг. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг үргэлжилнэ.

Ажлын хэсгийн танилцуулгыг уншина. Тийм ээ. Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна. Бас горимын санал гаргах юм байна. Тийм ээ.

**Ж.Сүхбаатар:** Эрхэм гишүүдийнхээ өглөөний мэндийг хүргэе.

Өнгөрсөн долоо хоногт чуулганы нэгдсэн хуралдаанаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлэг орсон.

Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах бас чиглэл өгсөн. Тэгээд учир нь шинээр сонгогдсон аймаг, нийслэлийн иргэдийн Хурлын дарга, Засаг дарга, төлөөлөгч нарын хувьд цахим хэлэлцүүлэг хийж, саналаа илэрхийлье гэдэг ийм санал гаргасан.

Мөн Нутгийн удирдлагын дэд хороо өнгөрсөн долоо хоногт бас хуралдаад тэгээд бас тодорхой шийдвэрүүдийг гаргаж нутгийн удирдлагын чиглэлээр ажиллана гэж ингэж төлөвлөсөн төлөвлөгөө нь бас санал, онолыг нь энэ орон нутгийн удирдлагыг сонсох ийм шийдэл гаргасан юм.

Тийм учраас хэлэлцүүлэг ингээд хэд хэдэн удаа ингээд үргэлжлээд байгаа нь нөхцөл байдал, орон нутгийн сонгууль болоод. Тэгээд саяны хэлдэг асуудлууд болоод. Ингээд бас энэ чинь том орон нутгийн бага Үндсэн

хууль гэж хэлж болохоор ийм ач холбогдолтой хууль учраас асуудлыг тал талын байр суурийг сонсох үүднээс ажлын хэсэг ажилласан.

Ингээд өнөөдөр анхны хэлэлцүүлгээ Байнгын хороон дээр үргэлжлүүлье. Тэгэхээр өмнө нь Байнгын хороогоор орж санал хураагдсан асуудлууд байгаа. Шийдэгдсэн.

Тэгэхээр өчигдөр манай ажлын хэсэг орой хуралдсан. Саналуудыг ингээд сонссон байгаа. Ингээд Та бүхэндээ тараагдсан нь 6 санал явж байна. 7 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэлээ. Тэгээд энэ саналыг хураалгаад ингээд анхны хэлэлцүүлгээ үргэлжлүүлээд Байнгын хороон дээр ингээд анхны хэлэлцүүлгээ эцэслэж дуусгая. Тэгээд чуулганы нэгдсэн хуралдаанд ингээд оруулаад явъя.

Одоо ингээд үргэлжлүүлээд нааш цааш болгохгүйгээр ингээд явах шаардлагатай байна. Түүнээс нэгжийн хуульд маргах, мэтгэлцэх юм бол нэг өгүүлбэр, нэг сэдэв нь удаан үргэлжилнэ.

Энэ чинь сүүлийн хэдэн жил үргэлжилсэн юм билээ. Хавар өргөн барьсан гишүүд өмнөх парламент дээр явагдсан хэлэлцүүлэг, судалгаа, төсөл боловсорсон. Одоо энэ дотор бас санаачлагч нь Д.Тогтохсүрэн, Х.Нямбаатар гишүүн, Ц.Мөнх-Оргил гишүүн, Ё.Баатарбилэг гишүүн, С.Бямбацогт гишүүн гээд манай 5 гишүүн энэ Улсын Их Хуралд нь сонгогдоод ажиллаж байгаа.

Тэгээд энэ асуудлыг Байнгын хорооны дарга маань ингээд энэ 7 зарчмын зөрүүтэй саналыг хураалгаж энэ асуудлыг анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны шатанд мухарлаж шийдэж өгөөч ээ гэж эрхэм гишүүдээсээ хүсэж байна.

Энэ нөгөө 6 санал дээрээ. Тийм. 7 дахь санал байгаад байгаа юм. Тэр нь үүнийг нэмж хураалгах санал байгаад байгаа. Ажлын хэсэг маань бас энэ өмчийн асуудал дээр. Их Хурлын дарга бас энэ дээр яриад байсан асуудал байгаа юм. Тэгээд бас байж болох хэмжээндээ л томьёолж байгаа. Энэ нь 18.1 дээр аймаг, сум, нийслэл, дүүрэг нь Үндсэн хуулийн 6.2-т зааснаас бусад өмчтэй байна гэсэн энэ томьёоллыг нэмж хураалгаж өгөөч ээ гэж.

Тэгээд нэг асуудал нь зөвхөн энэ 7 зарчмын зөрүүтэй саналаараа л саналаа хураалгаад. Өмнөх саналууд нь урьд нь хэлэлцэгдсэн учраас дэмжигдсэнээрээ ингээд явъя гэж байгаа юм. Чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж өгөөч гэж.

**Л.Энх-Амгалан:** Зарчмын зөрүүтэй саналын томьёолол уу? Яах вэ. Тэрийг нь яриад л явчихъя. Одоо та бичээд өгчих. Тэгэх үү?

Тэгэхээр одоо эхлээд цөмөөрөө ингэе. Эхлээд ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн. Горимын саналыг дэмжье гэснээр эхлээд санал хураалт хийе. Тэгж байж, дэмжигдэж байж нөгөө нэг зарчмын зөрүүтэй санал 7, С.Бямбацогт гишүүнийхтэй 8 ийм зарчмын зөрүүтэй саналаар шууд санал хураах гэсэн томьёоллоор.

Яах вэ. Хэрэв санал нээлттэй бол. Гэхдээ ямар ч байсан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын. Ингэе ингэе. Үгүй үгүй. Ер нь ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоороо санал хураалт хийе гэсэн ийм юугаар. Тэгэх үү? Тэгье. Санал хураалт. Гишүүд ээ. Тэгээд нээлттэй гэсэн үг шүү дээ. Хурууны хээгээр шүү. Одоо ZOOM биш шүү. Нөгөө юугаар явж байна шүү. Төхөөрөмжөөрөө явж байгаа шүү.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар энэ горимын санал дэмжигдэж байна.

Горимын санал дэмжигдсэн учраас одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт хийнэ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёололтой гишүүд байвал одоо энэ саналын томьёолол дээрээ бичээрэй. Тийм байна.

Нэг. Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор аймаг, сум, нийслэл, дүүрэг эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Амарсайхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Г.Ганболд, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалт. Гишүүд ээ.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Хоёр. Төслийн 18 дугаар зүйлийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч” гэсэн гарчгийг “Аймаг, сум, нийслэл, дүүргийн өмч” гэж өөрчлөх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт.

Энэ тэгэхдээ сумынх нь байгаа юм байгаа биз дээ. “Сумын өмч” гэдэг нь..? Аан. Энэ дээр чинь. “Аймаг, сум”. Аан.., за за.

Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Миний төхөөрөмж ажилласангүй. Тиймээс энэ саналыг хүчингүй болгож, саналыг дахин хурааж өгөхийг хүсье.

**Л.Энх-Амгалан:** Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын санал. Ж.Ганбаатар гишүүн горимын санал гаргасан учраас энэ горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт хийе.

Санал хураалт. Гишүүд ээ.

12 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 75.0 хувийн саналаар Ж.Ганбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё.

Ингээд хүчингүй болгож дахиж санал хураалт. Санал хураалт. Гишүүд ээ.

12 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 75.0 хувийн саналаар хоёр дахь санал дэмжигдэж байна.

Ажлын хэсэг бас энэ ZOOM-ээр оролцож байгаа юм байна. Тэгээд энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор асуух асуулттай. Асуухгүй. Үг хэлнэ шүү дээ. Тийм ээ. Үг хэлэх гишүүд байвал бас ажлын хэсэг оролцож байгаа юм байна шүү.

Гурав. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Дөрөв. Зарчмын зөрүүтэй 3 дахь санал дэмжигдвэл Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “нийслэл,” гэж нэмэх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 75.0 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Тав. Төслийн 61 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 61.1.22 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх.

“61.1.22.сумын Засаг даргын орлогч, Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;”.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Зургаа. Төслийн 62 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 62.1.22 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх.

“62.1.22.аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;”.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт.

Энэ 5, 6 дугаар зүйл хоёр чинь. Ж.Сүхбаатар гишүүн ээ. 5, 6 дугаар зүйл хоёр чинь. Санал хураалт шүү. Гишүүд ээ. Тийм байна.



12 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Тийм. Хоёр санал байгаа. Хаана байна..? Та унших уу? Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Би тэр 18.1.аймаг, сум, нийслэл, дүүрэг нь Үндсэн хуулийн 6.2-т зааснаас бусад өмчтэй байна гэсэн заалт.

Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь Үндсэн хуулийн 6.2-т зааснаас бусад өмчтэй байна.

Үндсэн хуулийн 6.2-т зааснаас бусад өмчтэй байна.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт хийе.

Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь Үндсэн хуулийн 6.2-т зааснаас бусад өмчтэй байна.

Санал хураалт. Гишүүд ээ.

Горимын санал гаргах юм уу? Д.Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Саяны Ж.Сүхбаатар гишүүний санал бол маш том заалт шүү дээ. Манайхан. 6.2-оос бусад өмчтэй байна гэдэг чинь орон нутгийн жишээлбэл. Хөөе. Ж.Батсууриа. Чи энэ үг сонс. Хөөе. Танай аймагтай холбоотой юм ярих гээд байна шүү дээ. Чи үг сонсохгүй юм.

Жишээ нь, энэ заалт байна шүү дээ ийм заалт байхгүй юу. Орон нутгийн уурхай байж болохгүй заалт. Нүүрсний уурхай.

Орон нутгийн өмчтэй юу байдаг юм. Өөр газраас ухаж. Магадгүй орон нутгийн өмчтэй ой модны аж ахуй ч байж болохгүй болчхож байгаа заалт байхгүй юу. Наадах чинь.

6.2-т зааснаас бусад өмчтэй байна гэж байгаа юм. 6.2 чинь нөгөө 8 зүйл байхгүй юу. Газрын баялаг, газар дээрх ой, ан, амьтан. Энэ чиглэлийн үйл ажиллагаанууд бүгд төрийн өмч байна. Орон нутгийн өмч байхгүй гэсэн заалт байхгүй юу.

Үгүй ээ. Та нар үгүй гэж. Энэ заалт чинь ийм заалт байгаа. Тэгэхдээ яах вэ саяны саналыг босгоно гэж ерөөсөө горим гаргахгүй. Манайхан ойлгох хэрэгтэй энэ заалтыг. Ойлгож та нар саналаа өгөхгүй. Хамаагүй заалтыг ойлгохгүй.

Түрүүн нэг заалтыг ойлгохгүй өгсөн. Гэхдээ би яах вэ дуугүй явуулчихсан. 34.2-ыг. Тийм. Тэгээд л явна. Ер нь энэ заалтаа та нар сайн ойлгож аваарай л гэж хэлэх гэж байгаа юм.

**Л.Энх-Амгалан:** За за. Тэгээд энэ зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй шүү дээ. Тийм ээ. Дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.3 дахь хэсэг нэмэх.

14.3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэрийг төрийн албан ёсны хэлээр нэрлэж, хаягийг монгол хэлээр нэрлэнэ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт. С.Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Түрүүн анхны хэлэлцүүлэг хийж байх явцад энэ санал гаргачхаад би бас Хууль зүйн байнгын хороо хурал давхцаад хуралд сууж амжаагүй.

Саналынхаа үндэслэлийг тайлбарлаж чадаагүй учраас гишүүд бас дэмжээгүй юм байна гэж ойлгож байгаа юм. Тийм болохоор энэ саналыг дахиж гаргаад саналыг дэмжиж өгөөч гэж хүсэх гэж байгаа юм.

Яагаад ингэж байгаа юм бэ гэхээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, нутаг усны нэрийг дур дураараа өөрчлөх, өөр өөрөөр нэрлэх ийм асуудал их гарч байгаа. Гадаад, дотоод янз янзын нэрээр нэрлэх.

Л.Энх-Амгалан дарга аа. Ганц санал хураалттай. Сууж бай л даа та. Та өөрөө саналаа өгчих л дөө. Тэгвэл байж байгаад. Та саналаа өгчих л дөө. Сууж байгаад. Тийм.

Тийм болохоор та бүхнийг дэмжээд өгөөч ээ гэж танаас хүсэж байгаа юм. Энэ саналыг. Гишүүд маань.

**Л.Энх-Амгалан:** Санал хураачихъя. Тэгэх үү..? Санал хураалт. Сая С.Бямбацогт гишүүний гаргасан. Энэ дэмжих ёстой. Найруулгын юутайгаар. Тийм ээ. Найруулгатайгаар. Тийм.

13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 69.2 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

**Д.Тогтохсүрэн:** Дараагийн санал хураалт. С.Бямбацогт гишүүний хоёр дахь санал хураалт байна.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн гарчгийн “зааг” гэснийг “нэгжийн нэр” гэж нэмэх.

С.Бямбацогт гишүүнд үг өгье. Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах үг өгье.

**С.Бямбацогт:** Энэ баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурал тогтооно гэж төсөлд явж байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид зөвхөн хилийн заагаас гадна тэр багийн нэрийг, хорооны нэрийг өөрчлөх эсэх асуудлыг тэр тухайн дээд шатных нь иргэдийн Хурал нь шийддэг байхаар. Засаг даргын өргөн мэдүүлснээр. Ингэж оруулахгүй бол бас л багийн нэрийг, хорооны нэрийг дур дураараа бас өөрчлөөд байх ийм асуудал гараад байх вий гэдгээс болгоомжилж ийм заалт оруулж байгаа юм.

**Д.Тогтохсүрэн:** С.Бямбацогт дарга аа. Та 8.3. Зарчмын зөрүүтэй саналын 8.3 дээр маш тодорхой орчихсон. Наадах чинь.

Бүр Засгийн газар тогтоохоор орчихсон.

**С.Бямбацогт:** Багийн нэрийг ч одоо Засгийн газар тогтоогоод байх нь зөв үү? Бас.

**Д.Тогтохсүрэн:** Та 8.3-аа уншаадах даа. Саяны зарчмын зөрүүтэй саналын.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатарын микрофоныг өгье. Ж.Сүхбаатар гишүүн тэр 8.3-аа уншаадах даа.

**Ж.Сүхбаатар:** Энэ ийм юм байгаа. С.Бямбацогт гишүүн ээ. Энэ бас тэгэхдээ нарийн юм билээ. Д.Цогтбаатар гишүүн нэг ийм асуудал тавиад.

Тэгээд бид ингэж томъёолсон. Хуулийнхаа юмыг хараад бас. Багийн оноосон нэрийг орон нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно гэж.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тэр оноосон нэрийнхээ зөвшөөрлийг авах ёстой юм. Тийм. Өөрөөр нэрлэсэн чинь бас янз бүрийн асуудал үүсэх гээд байсан юм. Тийм.

**Д.Тогтохсүрэн:** С.Бямбацогт гишүүнд микрофон өгье.

**С.Бямбацогт:** 8.3 дээр маш тодорхой орсон юм байна. Тийм учраас би саналаа татлаа. Нөгөө дэмжигдээгүй саналаас татчихаарай бас.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. С.Бямбацогт гишүүн гаргасан санал нь туссан учраас саналаа татаж авлаа.

Өөр саналтай гишүүн байна уу?

Г.Ганболд гишүүнийх хаана байна..? Энд байна уу? Энд бичиж өгсөн юм байна уу? Хаана байна..? Тэр бичиж өгснийг би уншаадахъя. Тэгж байж үг өгнө. Бичиж өгсөн нь хаана байна? Г.Ганболд гишүүний өгсөн зарчмын зөрүүтэй саналыг аваад ир.

Та тайлбарлаад. Тэг. Тайлбарлачих. Г.Ганболд гишүүний микрофоныг.

**Г.Ганболд:** Би зүгээр яах вэ ажлын хэсэг дээр цөөнх болсон юмаа л ярих гээд байгаа юм.

Байнгын хорооны гишүүд үүнийг нэг анхаараад авчхаарай гэж хэлэх гээд байгаа юм л даа. Энэ Засаг даргыг буцаах тухай асуудал дээр. Ийм байгаа шүү дээ. 58.7 дээр дээд шатны Засаг дарга, эсвэл Ерөнхий сайд тухайн нэр дэвшигчийг томилохоос татгалзаж болно.

58.8 дээр энэ зүйлийн 58.7-д зааснаар томилохоос татгалзсан тохиолдолд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 58.5-д заасан журмаар өөр хүнийг нэр дэвшүүлнэ гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зэрэг би үүнийг “өөр хүнийг” гэдгийг “дахин нэр дэвшүүлнэ” гэдгийг л би оруулах гээд байгаа байхгүй юу. Нэг ёсондоо Ерөнхий сайд юм уу, дээд шатны Засаг дарга улс төрийн шалтгаанаар ч юм уу татгалзах юм бол тэр хүн дахиж ирэх боломжгүй. Шууд заавал өөр хүн нэр дэвшүүлж ирүүлэх гээд байгаа байхгүй юу. Энэ дээр яах вэ би ажлын хэсэг дээр цөөнх болсон учраас үүнийг “өөр хүнийг” биш “дахин нэр дэвшүүлэх” гэдэг л юмыг оруулах.

**Д.Тогтохсүрэн:** “Өөр хүн” гэдгийг хасах гэдэг заалт оруулах гэж байна шүү дээ.

**Г.Ганболд:** Тийм. “Өөр хүн” гэдгийг хасах гээд байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол мэдээжийн хэрэг бид Ерөнхий сайд байнгын аль нэг намаас байхгүй. Улс төрийн шалтгаанаар бүгдийг нь буцаах болчихоод байгаа байхгүй юу. Тэгэх юм бол тэр хүн эргэж ирэхгүй. Заавал өөр хүн ирүүлэх болчихоод байгаа байхгүй юу.

**Д.Тогтохсүрэн:** Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн ахлагч. Ажлын хэсэг дээр цөөнх болсон юм байна. Ажлын хэсгийн ахлагчийн тайлбарыг сонсьё. Тэгээд санал хураана.

**Ж.Сүхбаатар:** Ер нь ажлын хэсэг дээрх цөөнх гэдэг ойлголт бол ер нь яригдаж болохгүй байгаа юм. Манай бусад гишүүд ч бас ойлгох ёстой байх. Ийм яриагаар ярьдаггүй. Ер нь явж ирсэн практиктай. Хэдийгээр асуудалтай ч гэсэн.

Яах вэ. Тэгээд нэг асуудал байгаа юм. Тэр “өөр хүний нэр” гэдэг нь Ерөнхий сайд нь. Жишээлбэл, одоо аймгийн даргын тухайд нэр дэвшиж байгаа хүнийг томилохоос татгалзчихаа байхад иргэдийн Хурал нь тэр хүнийгээ дахиад зүтгүүлээд ингээд тавихаар тэр хүн чинь томилж байгаа биш байхгүй юу.

Одоо манайхны хэлэх дуртай батламжилж байгаа болчихно. Үндсэн хуульд томилно гэж байгаа юм. Тэгээд энэ чинь цаад утгаараа дээд шатных нь харьяалж байгаа хүний юмыг үгүйсгэж байгаа байхгүй юу. Тэр хүн хамтран ажиллахад боломжгүй байна гээд асуудал тавьж байхад тэрийг дахиад зүтгүүлээд шийдэж байгаа юм.

Тэгэхээр энэ ямар асуудал үүсэж байна вэ гэхээр амьдрал дээр

цаашдаа ингээд явахад Ерөнхий сайд тэр аймгийн даргын хооронд улс төрийн зөрчлийг зориуд цаанаа дэвэргэж байгаа юм. Тэртээ тэргүй огцруулах хангалтгүй гэж үнэлэх эрх нь байж байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь зөвшилцөөний механизм байгаа юм.

Яах вэ. Энэ дотор манай зарим улсуудын яриад байгаа нь хурлууд яах вэ гэхээр зэрэг зарим хурлууд бол нөгөө дэмжигдэхгүй хүнээ эхэлж явуулчихаад тэгээд дэмжигдэх хүнээ дараа нь явуулж баталгаатай болгоно гэж ингэж яриад. Энэ бол улс төрийн харилцааны тэр янз бүрийн асуудлууд тэр үедээ яваад өнгөрөх байх.

Тэгэхэд бид үүнийг саяны “өөр хүний нэр дэвшүүлдэг” зарчим бол бусад томилгоонууд дээр байдаг байхгүй юу. Үндсэн хуулийн цэц дээр байна уу, Ерөнхий прокурор дээр байна уу, Их Хурлын дэмжлэг аваагүй тийм хүмүүс дээр өөр хүний нэр дэвшүүлдэг байхгүй юу. Өөр хүний нэр дэвшүүлдэг.

Тэгэхээр үүнийг бол яах вэ зүгээр бодох л асуудал. Энэ бол улс төрч болгоны өөрсдөө бодох асуудал боловч яг өнгөрсөн хугацаанд бидний явж ирж байгаа энэ чинь марзан байдалд ороод байгаа шүү дээ. Нөгөө Ерөнхий сайд нь эвгүй байдалд ороод л. Шууд нэг хүнийг дахин дахин тулгаад. Одоо томил чи гээд байдаг.

Тэгээд тэрний хооронд энэ бидний явсан энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед яригдаж байсан нэг асуудал бол харин ч бүр эсрэгээрээ Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргын тухайд давуу эрх эдэлье гэдэг ийм юм явж байсан шүү дээ. Дээрээсээ илүү томилгоо.

Томилно гэдгийн агуулгын эцсийн үр дүн нь томилох эрх бүхий субъект нь нэг томилсон шиг байх ёстой. Зүгээр манайх хослуулна гэж байгаа учраас бас ч гэж нөгөө харилцан зөвшилцөх тэр ажиллагаанууд яваад байгаа байхгүй юу.

Тэр одоо явж ирж байгаа чинь Ерөнхий сайд нь асуудал тавьж байгаа биш хурал нь ерөөсөө эцэслээд томилж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ хоёрын дундын зайг л олж байгаа. Аль алинд нь асуудал яригддаг уу. Яригддаг. Тэгээд одоо тэр нь тооцоолж бодох л асуудал байх. Зүгээр ингэж л юм байгаа юм. Тэгээд яах вэ гишүүд өөрсдөө шийдэх асуудал байх л даа.

**Д.Тогтохсүрэн:** Энэ ингэх юм байна. Г.Ганболд гишүүн ээ. Санал хураахгүй юм байна.

Энэ асуудал өмнө нь нөгөө зарчмын зөрүүтэй санал хураагдаад. Энэ дэгийн хуулиар зарчмын зөрүүтэй санал хураагдаад дэмжигдээд явчихсан учраас энэ төсөл дээр хураахгүй юм байна.

Харин чуулган дээр хэлэлцэх үед нь санал хэлээд Их Хурлын даргаас чиглэл өгвөл дараагийн хэлэлцүүлэг дээр хурааж болно гэж байна. Түүнээс одоогоор шууд таны саналыг өмнө нь ажлын хэсэг дэмжээд Байнгын хороон дээр дэмжигдээд явсан санал учраас тэр саналыг хүчингүй болгоод үүнийг

оруулна гэдэг ийм учраас хурааж болохгүй гэж байна.

Тэгэхээр та бол одоо саналаа чуулган дээр хэлээд тэгээд тэр санал хураалтын юманд яриад. Тэр дээр хэрэв дэмжигдчихвэл, тэр санал дэмжигдвэл тэрийг дахиж ярих повод нь гуравдугаар хэлэлцүүлэг дээр буюу эцсийн хэлэлцүүлэг дээр гарах юм байна шүү.

Зарчмын зөрүүтэй саналаар зарчим гаргахгүй гээд байна л даа. Н.Энхболд гишүүний микрофоныг.

**Н.Энхболд:** Д.Тогтохсүрэн дарга маш зөв зарчим хэллээ шүү. Одоо ингээд ажлын хэсгээс орж ирээд Байнгын хороон дээр дэмжигдчихээд. Магадгүй Байнгын хороо дахиад үргэлжлээд явж байхад энэ түрүүн дэмжигдээгүй. Одоо дахиж хураана гээд санал гаргаад ингээд байж ерөөсөө болохгүй. Тэрийг яг дэгээр нь яваад л.

Нэгэнт л Байнгын хороо шийдсэн бол чуулган руу ороод. Чуулган тэрийг нь яаж хандах нь вэ. Тэндээс нэмэлт чиглэл аваад явдаг юм уу, эсвэл чуулган дээр өөрчлөгдвөл дахиж ярина уу гэхээс ингээд л дахин дахин. Ялангуяа ингээд хэд хэдэн удаа анхны хэлэлцүүлгүүд тасалдаад, үргэлжлээд яваад байгаа тохиолдолд. Түрүүн уначихсан юм. Одоо дахиж хураалгана гээд ингээд явж болохгүй. Угаасаа дэгээрээ ч болохгүй.

Ер нь ч ажил энэнээс болж маш их маргаан гардаг. Энэнээс болж маш их саатдаг. Тэгэхээр энэ зарчмыг би бүр дахиад гишүүдэд сануулчихъя гэж бодлоо. Яагаад гэвэл одоо энэ Ерөнхийлөгчийн сонгуулийн хуультай холбоотой.

Бид нэгэнт ажлын хэсэг дээр асуудал яриад тэрийг шийдчихсэн бол дахиад ажлын хэсэг дээрээ үүнийг ярьж өгөөч гээд ингээд санал орж ирж байна. Аягүй бол Байнгын хороон дээр ярьж байхад дундуур нь дахиад үүнийгээ дахиад нэг хураалгачихъя ч гэдэг юм уу ийм юмнууд гарах шинжтэй болоод явчихлаа.

Тэгэхээр энэ болохгүй. Яг дэгээрээ, номоороо. Тэгээд олонхоороо асуудал шийдээд л явсан бол түүгээрээ явдаг байхгүй бол болохгүй.

Харин тэгж санал хурааж асуудлаа шийдэхээс өмнө маш сайн ярилцаж тал талаасаа ойлголцоод тэгээд ороод олонхоороо шийддэг энэ зарчмаараа бариад яв. Тэгж бодоод би сая Ардчилсан намынхныг завсарлага авахад нь бас элдэв горимын санал гаргасангүй л дээ. Яриад бас нэг үзэг. Яг Байнгын хороонд орохоосоо өмнө үнэхээр орхигдсон, үнэхээр чухал зарчмын ач холбогдолтой тийм асуудлууд байвал тэрийг нь бас нэг сонсьё гэж бодоод ингээд чимээгүй өнгөрсөн шүү гэдгийг хэлье.

**Д.Тогтохсүрэн:** Ингээд Г.Ганболд гишүүний саналаар санал хураах боломжгүй учраас гишүүд маань одоо зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Ингээд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.